**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 22 өдөр | Дугаар А/563 | Есөнбулаг сум

# Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны А/28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хан-Алтай ресурс” ХХК-нд гарсан хүнцлийн хордлогын тохиолдлын үед ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

2.Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэх, ажлын хэсгийг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (Ц. Лувсанцамц)-т үүрэг болгосугай.

3.Хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун)-т даалгасугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2015 оны
10 дугаар сарын 22-ны өдрийн А/363 дугаар
захирамжийн хавсралт

### "ХАН-АЛТАЙ РЕСУРС" ХХК-ИЙН АЖИЛТАН ӨРТСӨН ХҮНЦЛИЙН ХОРДЛОГЫН ТОХИОЛДЛЫН ҮЕД АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Ахлагч: | Ц.Лувсанжамц | (Онцгой байдлын газрын дарга) |
| Гишүүд | Н.Алтанбагана | (Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | О.Баатарчулуун | (Эрүүл мэндийн газрын дарга |
| | Д.Батмагнай | (Байгаль орчны газрын дарга) |
| | Н.Мэндбаяр | (Цагдаагийн газрын дарга) |
| | Д.Баттайван | (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга) |
| | Ж.Очир | (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга |
| | Р.Бүрэнбаясах | Мал эмнэлгийн газрын дарга) |
| | Э.Баттөр | (Тагнуулын Ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтсийн дарга |
| | Н.Золжаргал | Есөнбулаг сумын Засаг дарга Нарийн бичгийн дарга) |
| | Д.Сугар | (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга) |

__ oOo __